



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 01249

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюу толгой ХХК-ийн санхүүжилтээр Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дах Төлөөлөгчийн газартай хамтран хэрэгжүүлж буй өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих төслөөс хандивласан 8,494,500.0 (найман сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга таван зуу) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургууль (Л.Баянтуул)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургууль (Л.Баянтуул)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 4/ДЧ дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Чанар байдал	Хэмжээ	Хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Проектор	Asen 620		2024	шинэ	ш	1	1,299,900.00	1,299,900.00	Хандив
2	Агаар цэвэршүүлэгч	Air eco		2024	шинэ	ш	1	350,000.00	350,000.00	
Машин, тоног төхөөрөмжийн дүн									1,649,900.00	
3	Проекторын дэлгэц		120x240	2024	шинэ	ш	1	119,900.00	119,900.00	
4	Сургалтын сандал		100x60x60	2024	шинэ	ш	12	205,000.00	2,460,000.00	
5	Төмөр шүүгээ		170x30x60	2024	шинэ	ш	1	454,900.00	454,900.00	
6	Кресло			2024	шинэ	ш	1	650,000.00	650,000.00	
7	Бүйдэн			2024	шинэ	ш	1	750,000.00	750,000.00	
8	Хивс			2024	шинэ	м2	6	250,000.00	1,500,000.00	
9	Шүүгээ		40x40x40	2024	шинэ	ш	1	254,900.00	254,900.00	
10	Шүүгээ		120x60x30	2024	шинэ	ш	1	454,900.00	454,900.00	
11	Цагаан самбар		120x240	2024	шинэ	ш	1	200,000.00	200,000.00	
Тавилга, эд хогшлын дүн									6,844,600.00	
Нийт хөрөнгийн дүн									8,494,500.00	